



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ,  
ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН  
АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН САЛБАРЫН  
2026 ОНЫ I УЛИРЛЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Улаанбаатар хот

2026



**1**

**САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

**2**

**САЛБАРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

**3**

**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ, ҮНЭТ  
ЭДЛЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭ**

**4**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

**5**

**ХЯНАЛТ ШАЛГАЛТ**

**6**

**СУРГАЛТ**

**7**

**БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ**

**8**

**ДҮГНЭЛТ**



## **Товчилсон үгийн тайлал**

1. *Хороо-Санхүүгийн зохицуулах хороо*
2. *ҮМҮЧЭТХЭАЭ-Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч*
3. *ХЭ-Хувьцаа эзэмшигч*
4. *ХНХ-Хувь нийлүүлсэн хөрөнгө*
5. *ХНХХ - Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ*

## **Хүснэгт, зургийн жагсаалт**

*Хүснэгт 1. Салбарт хэрэгжиж буй журмууд*

*Хүснэгт 2. Үнэт эдлэлийн арилжааны бүтэц, эзлэх хувь*

*Хүснэгт 3. Хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт*

*Зураг 1. Зураг 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо*

*Зураг 2. Тусгай зөвшөөрлийн хүсэлт шийдвэрлэлт*

*Зураг 3 Бүртгэл, зөвшөөрлийн хүсэлт шийдвэрлэлт*

*Зураг 4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн байриил*

*Зураг 5. Орон нутагт ҮМҮЧЭТХЭАЭ иргэдийн байриил*

*Зураг 6. ХНХ-ийн хэмжээ*

*Зураг 7 Хөрөнгө оруулалтын бүтцийн хэмжээ*

*Зураг 8. Худалдан авсан болон худалдсан үнэт металлын хэмжээ*

*Зураг 9. Худалдан авсан болон худалдсан алтны хэмжээ*

*Зураг 10. Худалдан авсан болон худалдсан мөнгөний хэмжээ*

*Зураг 11. Худалдан авсан болон худалдсан үнэт эдлэлийн борлуулалт*

*Зураг 12. Хуулийн этгээдүүдийн 2025.I улирлын санхүүгийн үзүүлэлтийн тойм*

*Зураг 13. Хуулийн этгээдүүдийн 2026.I улирлын санхүүгийн үзүүлэлтийн тойм*

*Зураг 14. ҮМҮЧЭТХЭАЭ-ийн хуулийн этгээдүүдийн борлуулалтын орлого болон цэвэр ашгийн харьцуулалт*



## ҮМҮЧЭТХЭАЭ-ИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖУУД

### Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.9. үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа

### Зөвшөөрлийн тухай хууль

8.1 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн жагсаалт

2.20. үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа

### Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

4 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээд

4.1.8. энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээнд оролцсон бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

### Зөрчлийн тухай хууль

11.6 дугаар зүйл. Санхүүгийн үйлчилгээг хууль бусаар эрхлэх

1. Хадгаламж, зээл, төлбөр тооцооны, эсхүл хуульд заасны дагуу зөвшөөрөл, тусгай зөвшөөрөлтэй явуулах санхүүгийн бусад үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр, эсхүл хууль бусаар явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.29 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих

11.30 дугаар зүйл. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль зөрчих

1.2. Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоосон, эсхүл төлбөр тооцоо гүйцэтгэсэн, эсхүл зарлан сурталчилсан бол тухайн үйл ажиллагаанаас олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд зөрчлөө арилгах талаар эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг хэрэгжүүлээгүй бол тусгайлан олгосон эрхийг хасаж хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

### Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль



## ҮМҮЧЭТХЭАЭ-ИЙН САЛБАРЫН ХОЛБОГДОХ ЖУРМУУД


Д/Д	Журмын нэр	Баталсан огноо	Тогтоолын дугаар
1	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам	2020.03.25	150
2	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам	2023.06.23	233
3	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам	2020.12.23	1048
4	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	2020.03.25	151
5	Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам	2020.04.08	179
6	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам	2023.01.13	22

*Хүснэгт 1. Салбарт хэрэгжиж буй журмууд*




## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Тайлант улирлын байдлаар нэр бүхий 54 хуулийн этгээд, 522 иргэн ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 1-ээр буурч, иргэдийн тоо 37-оор өссөн үзүүлэлт юм.




Зураг 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо

Тайлант улиралд буюу 2026 оны I улиралд нэр бүхий 2 хуулийн этгээд, 18 иргэнээс дээрх төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэсэн.



Зураг 2. Тусгай зөвшөөрлийн хүсэлт шийдвэрлэлт

Тайлант улиралд тусгай зөвшөөрөлтэй ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдээс эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт болон хаяг байршлын өөрчлөлтийг бүртгүүлэх 3 хүсэлт ирүүлснийг хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэсэн.




Зураг 3. Бүртгэл, зөвшөөрлийн хүсэлт шийдвэрлэлт




## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН БАЙРШИЛ, БҮС НУТАГ

Тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгч иргэдийн 72.2 хувь буюу 377 нь Улаанбаатар хотод, 27.8 хувь буюу 145 иргэн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. ҮМҮЧЭТХЭАЭ иргэн, хуулийн этгээдүүдийг байршлаар ангилан харуулбал:



Зураг 4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн байршил


Орон нутагт арилжаа эрхлэгч иргэдийн үйл ажиллагаа эрхэлж буй байршлын дэлгэрэнгүйг зураг 5-д үзүүлэв.



Зураг 5. Орон нутагт ҮМҮЧЭТХЭАЭ иргэдийн байршил


## ҮМҮЧЭТХЭАЭ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ БҮТЭЦ

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ 54 хуулийн этгээд нь 84 хувьцаа эзэмшигчийн 6.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 4.5 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 36.3 хувиар тус тус буурсан байна.



Зураг 6. ХНХ-ийн хэмжээ

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн хувьцаа эзэмшигчдийн нийт ХНХ-ийн хэмжээ 6,484,526.1 мянган төгрөг байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай ҮМҮЧЭТХЭАЭ-ийн ХНХ-ийн нийт хэмжээ 816,000.0 мянган төгрөг буюу 12.6 хувийг эзэлж байна.



Зураг 7. Хөрөнгө оруулалтын бүтэц



Зураг 8. Худалдан авсан болон худалдсан үнэт металлын хэмжээ

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 408.3 кг үнэт металлыг 202.5 тэрбум төгрөгөөр худалдан авч, 429.9 кг үнэт металлыг 208.9 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан байна.



Зураг 9. Худалдан авсан болон худалдсан алтны хэмжээ

ҮМҮЧЭТХЭАЭ-д тайлант улиралд 374.4 кг алтыг 201.8 тэрбум төгрөгөөр худалдан авч, 383.8 кг алтыг 207.4 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан байна.



Зураг 10. Худалдан авсан болон худалдсан мөнгөний хэмжээ

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ-д нийт 33.6 кг мөнгийг 510.7 сая төгрөгөөр худалдан авч, 45.8 кг мөнгийг 1.3 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан байна.



## ҮНЭТ ЭДЛЭЛИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ этгээдүүд 4.7 тэрбум төгрөгийн үнэт эдлэл худалдан авсан бөгөөд 7.7 тэрбум төгрөгийн үнэт эдлэлийг худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт эдлэлийн үнийн дүн 1.2, худалдан борлуулсан үнэт эдлэлийн үнийн дүн 1.6 дахин буурсан үзүүлэлттэй байна.



Зураг 11. Худалдан авсан болон худалдсан үнэт эдлэлийн борлуулалт

## ҮНЭТ ЭДЛЭЛИЙН АРИЛЖААНЫ БҮТЭЦ, ЭЗЛЭХ ХУВЬ /тэрбум төгрөг/

ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ДҮН		
ТӨРӨЛ	ҮНИЙН ДҮН	ЭЗЛЭХ ХУВЬ
Нийт худалдан авсан үнэт эдлэлийн үнийн дүн	4.7	100%
Алтан эдлэлийн нийт үнийн дүн	3.0	63.8%
Мөнгөн эдлэлийн нийт үнийн дүн	1.5	31.9%
Бусад үнэт эдлэлийн нийт үнийн дүн	0.2	4.3%

ХУДАЛДСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ДҮН		
ТӨРӨЛ	ҮНИЙН ДҮН	ЭЗЛЭХ ХУВЬ
Нийт худалдсан үнэт эдлэлийн үнийн дүн	7.7	100%
Алтан эдлэлийн нийт үнийн дүн	4.0	51.9%
Мөнгөн эдлэлийн нийт үнийн дүн	3.4	44.2%
Бусад үнэт эдлэлийн нийт үнийн дүн	0.2	2.6%

Хүснэгт 2. Үнэт эдлэлийн арилжааны бүтэц, эзлэх хувь




ҮЗҮҮЛЭЛТ	2025.1	Нийт хөрөнгөд эзлэх хувь	2026.1	Нийт хөрөнгөд эзлэх хувь
<b>ХӨРӨНГӨ</b>				
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>72,138,977.8</b>	<b>84.0%</b>	<b>86,889,910.8</b>	<b>83.2%</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,566,297.4	13.5%	9,823,291.3	9.4%
Дансны авлага	6,228,332.3	7.3%	6,207,604.1	5.9%
Татвар, НДШ-ийн авлага	583,472.6	0.7%	545,382.4	0.5%
Бусад авлага	2,415,697.6	2.8%	4,739,133.9	4.5%
Бусад санхүүгийн хөрөнгө	5,100.0	0.0%	5,100.0	0.0%
Бараа материал	36,083,058.4	42.0%	42,585,225.0	40.8%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	15,214,327.2	17.7%	22,940,482.0	22.0%
Бусад эргэлтийн хөрөнгө	41,142.1	0.0%	42,142.1	0.0%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгө	1,550.0	0.0%	1,550.0	0.0%
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>13,745,194.3</b>	<b>16.0%</b>	<b>17,525,227.2</b>	<b>16.8%</b>
Үндсэн хөрөнгө	12,299,723.1	14.3%	16,047,226.7	15.4%
Биет бус хөрөнгө	1,000,465.3	1.2%	1,036,969.6	1.0%
Биологийн хөрөнгө	0.0	0.0%	5,190.0	0.0%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	408,604.1	0.5%	408,604.1	0.4%
Хойшлогдсон татварын хөрөнгө	29,015.8	0.0%	25,040.8	0.0%
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.0	0.0%	1,406.0	0.0%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	7,386.0	0.0%	0.0	0.0%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>85,884,172.0</b>	<b>100.0%</b>	<b>104,415,138.0</b>	<b>100.0%</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>				
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>38,988,076.1</b>	<b>45.4%</b>	<b>49,072,600.0</b>	<b>47.0%</b>
Дансны өглөг	17,742,667.7	20.7%	17,572,650.2	16.8%
Цалин, татвар, НДШ-ийн өглөг	3,166,085.9	3.7%	3,520,520.1	3.4%
Банкны богино хугацаат зээл	3,432,246.2	4.0%	3,555,414.2	3.4%
Хүүний өглөг	1,028,764.4	1.2%	1,813,437.1	1.7%
Ногдол ашгийн өглөг	0.0	0.0%	1,319.9	0.0%
Урьдчилж орсон орлого	7,018,021.6	8.2%	14,859,698.4	14.2%
Нөөц /өр төлбөр/	15,654.1	0.0%	33,671.3	0.0%
Бусад богино хугацаат өр төлбөр	6,584,636.2	7.7%	7,715,741.2	7.4%
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>10,877,891.9</b>	<b>12.7%</b>	<b>13,972,560.3</b>	<b>13.4%</b>
Урт хугацаат зээл	10,653,620.4	12.4%	12,809,328.4	12.3%
Хойшлогдсон татварын өр	10,097.2	0.0%	12,359.6	0.0%
Бусад урт хугацаат өр төлбөр	214,174.3	0.2%	1,150,872.4	1.1%
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>49,865,968.0</b>	<b>58.1%</b>	<b>63,045,160.4</b>	<b>60.4%</b>
<b>Эздийн өмч</b>	<b>36,018,204.0</b>	<b>41.9%</b>	<b>41,369,977.7</b>	<b>39.6%</b>
Өмч	10,164,429.1	11.8%	6,484,526.1	6.2%
Халаасны хувьцаа	-168,000.0	-0.2%	168,000.0	0.2%
Нэмж төлөгдсөн капитал	2,278,232.1	2.7%	2,278,232.1	2.2%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	873,381.7	1.0%	713,396.1	0.7%
Эздийн өмчийн бусад хэсэг	1,423,009.6	1.7%	1,370,236.4	1.3%
Хуримтлагдсан ашиг	21,447,151.6	25.0%	30,691,587.0	29.4%
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>36,018,204.0</b>	<b>41.9%</b>	<b>41,369,977.7</b>	<b>39.6%</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>85,884,172.0</b>	<b>100.0%</b>	<b>104,415,138.0</b>	<b>100.0%</b>

Хүснэгт 3. Хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт

## ҮМҮЧЭТХЭАЭ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

### 2025.1 УЛИРАЛ

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарын 2025 оны I улирлын тайлангийн нэгтгэлд 52 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд 10,164.4 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 85,884.2 сая төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.



Зураг 12. Хуулийн этгээдүүдийн 2025.1 улирлын санхүүгийн үзүүлэлтийн тойм

### 2026.1 УЛИРАЛ

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарын 2026 оны I улирлын тайлангийн нэгтгэлд 54 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд 6,484.5 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 104,415.1 сая төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.



Зураг 13. Хуулийн этгээдүүдийн 2026.1 улирлын санхүүгийн үзүүлэлтийн тойм

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн ХНХ, нийт хөрөнгө, хуримтлагдсан ашгийн нийт дүнд дараах өөрчлөлт гарсан байна.



## ҮМҮЧЭТХЭАЭ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ЦЭВЭР АШИГ

Тайлант хугацаанд нэр бүхий 54 хуулийн этгээд нь 25,603,688.69 мянган төгрөгийн нийт орлоготой, 21,936,534.73 мянган төгрөгийн нийт зардалтай, 3,667,153.95 төгрөгийн цэвэр ашигтайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байна.



Зураг 14. ҮМҮЧЭТХЭАЭ-ийн хуулийн этгээдүүдийн борлуулалтын орлого болон цэвэр ашигын харьцуулалт


ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн нийт зардлын 51.9 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 16.5 хувийг ерөнхий ба удирдлагын зардал, 10.7 хувийг борлуулалт, маркетингийн зардал, 19 хувийг санхүүгийн зардал, 1.9 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

### 2026.I УЛИРАЛ – НИЙТ ЗАРДЛЫН БҮТЭЦ, ЭЗЛЭХ ХУВЬ






Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдээс нийт 54 санхүүгийн тайлан, 255 арилжааны мэдээ ирүүлснийг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулсан болно.



ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаанд 2026 онд хэрэгжүүлэх хяналт шалгалт, зөрчилтэй этгээдэд авах арга хэмжээ, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн худалдааны төвүүдэд ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа явуулж буй этгээдүүдэд Сорьцын хяналтын газартай хамтран газар дээрх шалгалтыг хэрэгжүүлэх удирдамжийг батлуулж, шалгалтын бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.



Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-д өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан.

Дээрх зохицуулалтын дагуу 2026 оны I дүгээр улирлаас эхлэн ҮМҮЧЭТХЭАЭ-ээс санхүүгийн тайлан болон арилжааны мэдээг зөвхөн цахим хэлбэрээр буюу Фин-А системээр хүлээж авахаар шийдвэрлэлээ.



Гаалийн ерөнхий газраас зохион байгуулсан сургалт, мэдээллийн арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хороо оролцож, ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарын нөхцөл байдал, зохицуулалт болон холбогдох мэдээллийг гаалийн албан хаагчдад танилцуулж ажиллалаа.



**ЗОРИЛГО:** Салбарын зохицуулалт, хууль эрх зүйн орчны талаар мэдээлэл өгөх, хуулийн хэрэгжилтийг хангах, хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх.



## ХУУЛЬ БУС ОЛБОРЛОЛТООС урьдчилан сэргийлэх сургалт, хэлэлцүүлэг



**ЗОРИЛГО:** Хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, иргэд, аж ахуйн нэгжийн хууль тогтоомжийн мэдлэгийг нэмэгдүүлэх.





ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, олон улсын туршлага судлах чиг үүрэг бүхий зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын даалгавар 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр батлагдав.

✓	✓	✓	✓
ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛСНЭЭР ТОГТВОРТОЙ ХӨГЖИХ НӨХЦӨЛ БҮРДЭНЭ.	ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА НЭВТРҮҮЛЭХ	ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ	ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

**ХИЙСЭН АЖИЛ**

Санхүүгийн зохицуулах хорооноос ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн алтны борлуулалтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээлэл солилцоог сайжруулах чиглэлээр Монголбанктэй хамтарсан уулзалтыг зохион байгуулсан.

**МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК**

ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ,  
МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

**ЦААШИД ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГУУД**

Татварын ерөнхий газар,  
Гаалийн ерөнхий газар,  
Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам зэрэг холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээлэл солилцоог сайжруулах чиглэлээр хамтран ажиллана.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР	ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР	АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ	БУСАД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУД

**ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

ХАМТЫН АЖИЛЛАГАА ӨРГӨЖИНЭ	МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОО САЙЖИРНА	АЛТНЫ БОРЛУУЛАЛТ НЭМЭГДЭНЭ	ИЛ ТОД, ЭРСДЭЛГҮЙ ОРЧИН БҮРДЭНЭ	ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭРЭГЖИЛТ ДЭМЖИГДЭНЭ




Тайлант хугацааны байдлаар нэр бүхий  
54 хуулийн этгээд, 522 иргэн ҮМҮЧЭТХЭА-ийн  
үйл ажиллагаа эрхэлж байна.



Мөн зохицуулалттай этгээдүүдээс тайлант улиралд 54 санхүүгийн тайлан, 255 арилжааны мэдээ ирүүлснийг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулсан болно.

Нийт арилжаа эрхлэгч иргэдийн 72.2% нь Улаанбаатар хотод төвлөрч байна.



Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 408.3 кг үнэт металлыг 202.5 тэрбум төгрөгөөр худалдан авч, 429.9 кг үнэт металлыг 208.9 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан байна.

